



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 4/333

Улаанбаатар хот

Гэрээт ажил, бүтээгдэхүүний бүтээмж,  
чанарыг сайжруулах, үр дүнг тооцох тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БХБЯамны болон тус газрын захиалгатай гүйцэтгэгч болон зөвлөх компанитай байгуулсан гэрээт ажлуудын явцын болон эцсийн шатны тайлан, дүгнэлтийг хүлээн авч мэргэжлийн дүгнэлт гаргаж буй мэргэжилтэн нь уг гэрээт ажлыг ажлын даалгаврын хүрээнд холбогдох стандарт, норм, дүрэм, журмыг баримталж ажилласан эсэхэд дүгнэлт өгч, ажил бүтээгдэхүүний чанар, үр дүнгийн талаар эцсийн хариуцлага хүлээхийг анхааруулсугай.

2. Гүйцэтгэгчээс ирүүлсэн гэрээт ажлын дүгнэлт, тайланг хүлээн авсан тухай акт, тайланг үйлдэхдээ ямар нэр төрлийн бүтээгдэхүүн хүлээн авсан тухай тодорхой тусгах, ажлын үр дүнг гүйцэтгэлийн хувиар тооцох бус, бодитой хийж гүйцэтгэсэн бүтээгдэхүүн, үр дүнгээр тооцож ажиллахыг даалгасугай.

3. Гэрээт ажлын хүрээнд бэлэн болсон бүтээгдэхүүн түүний үр дүнг анхан шатны болон орон нутаг дахь хэрэглэгчид хүлээн зөвшөөрч, ашиглаж үр дүнг мэдэрсэн үнэлэлт дүгнэлтийг гаргуулж байхыг дурьдсугай.

4. Нийт гэрээт ажлуудын биелэлтийн явц, хэрэгжилтийг сайжруулах үүднээс ажлын даалгавар болон стандарт, норм, зааврын дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, гэрээгээр хүлээсэн хугацаандаа багтаж үүргээ гүйцэтгэж ажиллахыг холбогдох гүйцэтгэгч болон зөвлөх компаниудад анхааруулж

ажиллахыг тус газрын алба, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн болон мэргэжилтнүүдэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



А.ХҮРЭЛШАГАЙ